



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хот нийтийн аж ахуйн
чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Хууль тогтоомжийн хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах, 2026 онд хийгдэх тохижилт, ногоон байгууламж, хог хаягдал, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх, мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог хангуулах зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг.Иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

1.1.дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудын хариуцах орчны 50 метр талбайд Худалдаа үйлчилгээ эрхлэх байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулж, өнгө үзэмжийг сайжруулах, фасад, гадна орчны угаалга цэвэрлэгээ хийлгэж, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах, орчны аюулгүй байдлыг хангуулахад чиглэсэн арга хэмжээ авч, хяналт тавих, зөрчлийг арилгуулах;

1.2.хотын өнгө үзэмжийг сайжруулах хүрээнд гэрлэн чимэглэл бүхий ногоон байгууламжийг тодорхой байршилд нэмэгдүүлэн, мөн хаяг, хаягийн байгууламжийг хотын стандартад нийцүүлж, дүүрэгт бүрт жишиг гудамж бий болгох ажлыг зохион байгуулах;

1.3.ногоон байгууламжид тавигдсан болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд худалдаа үйлчилгээ явуулах зорилгоор тавигдсан ч ашиглагдахгүй байгаа сүүдрэвч, саравчнуудыг буулгах, суурийг бүрэн авах, орчныг цэвэрлэх;

1.4.төвийн 6 дүүргийн автобусны эцсийн болон дундын зогсоолууд дахь хуучин сүүдрэвчүүдийн өнгө үзэмжийг сайжруулж, будаж засварлан, сандал, хогийн сав байршуулах ажлыг зохион байгуулах;

1.5.явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй шон, гадас, хаалт, хашлага зэргийг буулгаж аюулгүй байдлыг хангуулах, эвдрэл бүхий явган замыг засварлах, сул шороон хөрс бүхий газрыг зүлэгжүүлэх, хатуу хучилттай болгон тохижуулах ажлыг 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах;

1.6.гуу жалга далан сувгийн ахуйн хог хаягдлыг иргэдийн бүлгээр бүрэн цэвэрлүүлэх, шар усны үерээс сэргийлэх, далан сувгийн урсцыг сайжруулах бэлтгэл хангах;

1726010002

1.7.хөрсний болон агаарын бохирдлоос сэргийлэх хүрээнд гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах;

1.8.дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн хур хогийн цэг, нохой муур, малын сэг зэмийг ачиж тээвэрлэх, орчны ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх ажлыг зохион байгуулах, хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэх, булшлах;

1.9.нохой муурын тоо толгойг бууруулах хүрээнд шинэ технологи арга ажиллагааг туршиж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Хоёр.“Авто замын тухай хууль”, “Автотээврийн тухай хууль”, “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”, “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”, “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”, болон холбогдох стандартыг хангуулах, хяналт, шалгалт хийх, хөдөлгөөн зохион байгуулалтад ажил үүргийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр), Нийтийн тээврийн бодлогын газар (Г.Билгүүн), Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан), Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр), Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар (Л.Галбадрах), дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2.1.авто замын болон явган замын эгнээ тусгаарлах хайсыг стандартын дагуу байрлуулах, бүрэн бүтэн байдлыг хангах, засвар арчлалт, нөхөн сэргээх шилжүүлэх ажлыг хийх;

2.2.нийслэлийн авто замуудад ачааны автомашины хөдөлгөөнийг бүх жин, даац, замын хөдөлгөөний ачаалал зэргийг харгалзан цаг болон гарагийн хязгаарлалт тогтоосон нэмэлт тэмдгийн хамт хориглох тэмдгийг шинээр байрлуулах, өмнө тавигдсан хориглох тэмдгүүд бүрэн байгаа эсэхэд үзлэг шалгалт явуулж, судалгаа гарган шаардлагатай газруудад тэмдгийг шинээр хийж байрлуулах;

2.3.замын хөдөлгөөнд оролцож буй хүнд даацын тээврийн хэрэгслийн ачаа тээвэрлэлт, техникийн бүрэн бүтэн байдал, жин даац, зам, замын байгууламжийн ашиглалтад хяналт, шалгалт хийх;

2.4. барилга, замын ажил гүйцэтгэхэд техникийн ерөнхий шаардлага, барилгын ажилд тавих аюулгүйн ерөнхий шаардлагыг хангуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;

2.5.барилгын талбайд том оврын ачаа тээврийн машин, механизмын дугуйг угаалгах, орчны бохирдол, авто замын тоосжилт, эвдрэл гэмтлийг бууруулах, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход харгалзан үзэх;

2.6.орон сууц, хороолол дундах болон туслах зам, гэр хорооллын гудамжны явган хүний зам, авто замын эвдрэл, гэмтлийг сэргээн засварлах.

Гурав.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр автомашины хөдөлгөөнийг хязгаарлаж шон, хашаа хаалт, түгжих хэрэгсэл байрлуулсан, гинж тросс татсан үйлдлүүдийг таслан зогсоож гэм буруутай этгээдээр авто зам, явган зам, ногоон байгууламжийг эргүүлэн хэвийн байдалд оруулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр), Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т тус тус даалгасугай.

Дөрөв.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хашаалсан, нийтийн эзэмшлийн газрыг чөлөөлж тохижуулах, эзэмшиж буй газраа тохижуулаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн газар зохион байгуулалтын алба (Г.Мөнхбаатар)-нд даалгасугай.

Тав.Нийтийн зориулалттай орон сууцны хорооллын орчны газрыг тохижуулах, арчлах, цэвэрлэх, тохижилтын бүрдэл хэсгүүдийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангуулах, хаврын цэвэрлэгээ арчлалт хийлгэх ажлыг зохион байгуулахыг Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл ГҮТББ (М.Галбаатар)-д даалгасугай.

Зургаа.Дулаан болон бусад автобусны зогсоолууд, мэдээллийн самбаруудыг угаалгаж, өнгө үзэмжийг сэргээх, эвдрэл гэмтлийг засварлаж, иргэдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх нөхцөлийг хангаж ажиллахыг Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газар (Г.Билгүүн), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Жэй Си Дэко Монголиа ХХК, Си Си Ти Эс ХХК-д тус тус даалгасугай.

Долоо.Усан оргилуур, хөшөө дурсгал, нийтийн бие засах газар зэрэг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг засварлах, усан оргилуурыг 06 дугаар сарын 01-ний өдрөөс ажиллуулах бэлтгэл зохион байгуулалтыг хангах, ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрч, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгүүдийг актлах ажлыг зохион байгуулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Г.Ууганбаяр), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар-т даалгасугай.

Найм.Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэнд, боловсролын ажил үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын орчны 50 метрт бий болгосон ногоон байгууламжуудыг арчлах, тохижилтыг сайжруулж, аюулгүй байдлыг хангуулах, хайс хашлагануудыг засварлах өнгө үзэмжийг сэргээж будуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Н.Наранбаатар), Нийслэлийн Боловсролын газар (Б.Амартүвшин)-т даалгасугай.

Ес.Инженерийн шугам сүлжээний худгийн тагуудын бүрэн бүтэн байдалд 2026 оны 04 дүгээр сард багтаан үзлэг шалгалт явуулж, шинэчилж солих, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, авто зам, явган замын байгууламжид хийгдсэн худгийн тагуудын түвшин тааруулах ажлыг 2 дугаар улиралд багтаан засварлаж, шинэчлэх, тэдгээрт шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс шийдвэрлэхийг ашиглалт хариуцсан инженерийн хангамжийн байгууллагууд (Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ, Хувийн орон сууц, нийтийн аж ахуйн

мэргэжлийн холбоо ТББ, Орон сууц нийтийн аж ахуйн мэргэжлийн холбоо ТББ-ын удирдлагууд)-д үүрэг болгосугай.


Арав.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд болон орон сууцны хороолол дотор байгаа хогийн бункер, цинкэн савнуудыг будаж засварлах, өнгө үзэмжийг сайжруулах, ариутгаж халдваргүйжүүлэх арга хэмжээ авахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Г.Ууганбаяр)-т болон Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл ГҮТББ (М.Галбаатар)-д, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

Арван нэг.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн шон, замын хөдөлгөөний гэрлэн дохионы шонгуудын унжсан болон ил байгаа утас, цахилгааны болон шилэн кабелиудыг цэгцлэх, тагжуулах зэргээр иргэдийн аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Мэдээлэл холбоо сүлжээ ХХК (Н.Наранбаатар), дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-т даалгасугай.

Арван хоёр.Үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээний ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэх, зориулалтын машин механизмаар соруулж үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ (Б.Бямбасайхан)-т даалгасугай.

Арван гурав.Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр нэгтгэн тайлагнаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Г.Батзориг), илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр), Нийслэлийн Байгаль орчны газар (Н.Мөнхбаяр)-т, албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн ажлаа олон нийтэд сурталчилж, мэдээллээр хангаж ажиллахыг нийт байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

